



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөө аж ахуйн их сургуулийн харья Булган аймаг дахь Политехник коллежийн
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2025/137/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2025 он	Дарга, тэргүүлэх аудиторовын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn Аудитор: А.Сувдаа Утас: 70342495 Цахим хаяг: suvdaaa@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.28 № 312

танай _____ ны № _____ т

ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛИЙН
ХАРЬЯА БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН
ЗАХИРАЛ Н.ПҮРЭВСАЙХАН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ХААИС-ийн харьяа Булган аймаг дахь Политехник коллежийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно

Жилийн эцсийн тооллогыг үнэн зөв хийгээгүй, дотуур байрны хүүхдийн хооол хүнсний материал, нүүрс худалдан авах тендерийг хуулийн дагуу зохион байгуулаагүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Засгийн газрын 2023 оны 306 дугаар тогтоолоор ХААИС-ийн харьяа Булган

632503557

аймаг дахь Политехник коллеж байгуулах шийдвэр гарсны дагуу үйл ажиллагаагаа явуулсан байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн 266 дугаар тогтоолоор эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансад бүргэжээ.

Аудитын гол асуудал

ХААИС-ийн харьяа Булган аймаг дахь Политехник коллеж Засгийн газрын 2023 оны 306 дугаар тогтоолоор үүсгэн байгуулагдсан ч Боловсролын ерөнхий газар бүтэц, орон тоог баталж өгөөгүй байна.

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ЭНХЦООДОЛ

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/мянган төгрөг/

	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	-	929,447.8
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	4,831,902.5
	Нийт хөрөнгийн дүн	-	5,761,350.3
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	-	5,761,350.3
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	-	5,761,350.3
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	-	9,849,604.4
	Үйл ажиллагааны зардлын дүн	-	4,083,749.0
	Үйл ажиллагааны үр дүн	-	5,765,855.4
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	-	5,765,855.4
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	(5,140,922.9)
	Тайлант оны үр дүн	-	5,765,855.4
	Эцсийн үлдэгдэл	-	624,932.5
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	-	4,337,764.6
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	-	4,177,389.0
	Үйл ажиллагааны ЦМГ	-	160,375.6
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	(37,976.1)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	122,399.5
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	122,399.5
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	4,213,213.3
	Урсгал зардал	-	4,213,213.3
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	4,335,612.7
	Улсын төсвөөс санхүүжих	-	3,786,227.9
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	33,087.6

Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага “Хөдөө аж ахуйн салбарын эрэлтэд нийцсэн, чадамжтай мэргэжилтэн бэлтгэх” зорилгын хүрээнд ажиллажээ.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,660,474.3 мянган төгрөгийн 82 удаагийн орлого, 600,185.7 мянган төгрөгийн 45 удаагийн зарлагын гүйлгээг бүрэн мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, Засгийн газрын

2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтын 3.2.10-д заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж, зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлан баталгаажуулах аудитын хүрээнд хүний нөөц болон цаг хугацааны хязгаарлагдмалаас дараагийн аудитаар батлагдсан бүтэц орон тоо, холбогдох батлагдсан төсвийн хүрээнд зарласан худалдан авалт, өөрийн орлогоос эрх нээлгүүлж зарцуулалт хийхдээ Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулсан болон албан хаагчдын ээлжийн амралтын олговрын гүйцэтгэлийн байдлыг авч үзэх.

Зургаа. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 15,519.2 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 5,519.2 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- Үндсэн хөрөнгийн элэгдлийг дутуу тооцоолсон нь УСНББОУС-17, тасалбар болголт байх батламж мэдэгдэл,
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 05 дугаар сарын 30-ны 266 дугаар тогтоолд тусгагдсан авлагыг тайланд тусгаагүй нь УСНББОУС 1, тасалбар болголт, тохиолдсон байх батламж мэдэгдэл,
- Түүвэр тулгалтаар "Маргад-Орхон" ХХК руу харилцахаас шилжүүлсэн дүнгээс 205.4 мянган төгрөгийг бараа материал орлого авсан ч тооцоо нийлээгүй, авлага дутуу бүртгэж тайлагнасан нь УСНББОУС 1, 12, тасалбар болголт, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

Аудитаар нийт 2,546,868.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 2,363,609.3 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 183,259.5 мянган төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох 1 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 286,208.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 225,838.6 мянган төгрөгөөр их тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

6.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

6.2 Албан шаардлага

1. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 05 дугаар сарын 30-ны 266 дугаар тогтоолын дагуу 5 хүний бүрэлдэхүүнтэй тооллогын комисс томилогдсон 2024 оны 06 дугаар сарын 02-15-ны хооронд тооллого хийсэн байна. Тус тооллого хийгдэхээс өмнө буюу 2024.01.01-2024.06.01-ний хооронд зарцуулсан бараа материалыг тоолж 2023 оны 12 дугаар сарын 31-ний дүнгээр илэрхийлсэн нь НББ-ийн тухай хуулийн 12.3, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4, Төсвийн тухай хуулийн 16.5.6-д заасныг бүрэн хэрэгжүүлээгүй,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

нийцсэн бөгөөд зохистой байх, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох

2. Жилийн эцсийн тооллогыг захирлын А/101 дүгээр тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй тооллогын комисс байгуулж 2024 оны 12 дугаар сарын 25-ны дотор дууссан гэх ч тооллогын дүнг 2024 оны 12 дугаар сарын 31-ний дүнгээр илэрхийлсэн буюу тооллогыг үнэн зөв чанартай хийгээгүй байна. 2024 оны 12 дугаар сарын 25-аас 31-ний өдрийн хооронд ерөнхий журналаар 62,310.2 мянган төгрөгийн орлого, 11,169.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4, 73.2, Төсвийн тухай хуулийн 16.5.6-д заасныг бүрэн хэрэгжүүлээгүй, *нийцсэн бөгөөд зохистой байх, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож холбогдох хууль, журмын заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах

3. Жилийн эцсийн тооллогыг захирлын А/101 дүгээр тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй тооллогын комисс байгуулж 2024 оны 12 дугаар сарын 25-ны дотор дууссан гэх ч тооллогын дүнг 2024 оны 12 дугаар сарын 31-ний дүнгээр илэрхийлсэн буюу тооллогыг үнэн зөв чанартай хийгээгүй байна. 2024 оны 12 сарын 25-аас 31-ний өдрийн хооронд ерөнхий журналаа 19,469.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого бүртгэгдсэн нь НББ-ийн тухай хуулийн 12.3, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2, 72.4, Төсвийн тухай хуулийн 16.5.7-д заасныг бүрэн хэрэгжүүлээгүй, *нийцсэн бөгөөд зохистой байх, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож холбогдох хууль, журмын заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах

4. Тайлант онд 2024-2025 онд хичээлийн жилд цогц сургалтыг үе шаттай зохион байгуулахаар "Майнд сет Институт" 10,000.0 мянган төгрөгийн гэрээ хийсэн ч тайлант онд гэрээний нийт дүнгээр зардал хүлээн зөвшөөрсөн, 2025 онд ногдох дүнгээр урьдчилж төлсөн зардлаар бүртгээгүй нь УСНББОУС 1, 2, НББ-ийн тухай хуулийн 6.1, 20.2.3, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар "Төсвийн байгууллагын дагж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 9-д заасныг зөрчсөн, тасалбар болголт болон эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож холбогдох стандарт, журмын заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах,

5.Тайлант онд дотуур байрны хүүхдийн хоолны материал, нүүрс худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу хэрэгжүүлээгүй тул удирдах албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлагыг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

6.3 Зөвлөмж

1. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 82 нэр төрлийн 335 тооны хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулах газрын 2019 оны 271 дүгээр тогтоол "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.6-д заасныг бүрэн хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.6-д заасныг хэрэгжүүлж, холбогдох ажлыг зохион байгуулах

2. Өөрийн орлого болох заалны түрээс болон хичээл үйлдвэрлэлээс нийт хэдэн төгрөгийн орлого бүрдүүлэх тооцоолол хийгээгүй, түрээсийн орлогын дүн анхан шатны баримтын дүнгээр их байгаа нь НББ-ийн тухай хуулийн 13.1, 20.2.5, Төсвийн тухай хуулийн 16.5.6-д заасныг хэрэгжүүлээгүй, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Багш нарын оруулж буй орлогын дүн харилцан адилгүй байгааг нэг мэргэжлийн багш нарын төвлөрүүлэх орлогын зөрүүнд анхаарах, эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлж боломжит хувилбараар тооцоолол хийн жилийн эцэст баталгаажуулах, мөн түрээсийн орлогын дүнг анхан шатны баримтын дүнтэй тооцоо нийлэх.

Долоо. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган.төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Албан шаардлага	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ХААИС-ын харьяа Политехник коллеж	4	15,519.2	3	5,519.2	1	10,000.0	3	5,519.2	1	10,000.0	1	10,000.0
Дүн	4	15,519.2	3	5,519.2	1	10,000.0	3	5,519.2	1	10,000.0	1	10,000.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган.төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
ХААИС-ын харьяа Политехник коллеж	6	276,208.8	-	-	3	92,949.3	2	-	1	183,260	-	-
Дүн	6	276,208.8	-	-	3	92,949.3	2	-	1	183,260	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган.төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ХААИС-ын харьяа Политехник коллеж	1.0	2,260,660.0			1.0	2,260,660.0		
Дүн	1.0	2,260,660.0	-	-	1.0	2,260,660.0	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн		-	-	-	-	-	-	-
Нийт дүн	1.0	2,260,660.0	-	-	1.0	2,260,660.0	-	-

Найм. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Байгууллага, нэгжийн тоо	Санал дүгнэлтийн хэлбэр
---	--------------------------	-------------------------

	Төсвийн захирагчийн ангилал	Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр						
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		

-oOo-